



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН 2020 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН ШИНЭЧИЛСЭН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2011-2020)

**I БҮЛЭГ. МУИС-ИЙН 2011-2020 ОНЫ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ
ТӨЛӨВЛӨГӨӨГ ШИНЭЧЛЭХ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**II БҮЛЭГ. МУИС-ИЙН 2020 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ,
ЕРӨНХИЙ ЗОРИЛГО**

2.1 АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, УРИА, ҮНЭТ ЗҮЙЛС.

2.2 2020 ОН ХҮРТЭЛХ СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

**III БҮЛЭГ. 2020 ОН ХҮРТЭЛХ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЗОРИЛТУУД**

I БҮЛЭГ. МУИС-ИЙН 2011-2020 ОНЫ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ШИНЭЧЛЭХ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

МУИС нь бүрэлдэхүүн 5 сургууль, орон нутаг дахь харьяаллын 2 сургууль, үндэсний статустай 3 хүрээлэн, судалгааны бусад нэгжүүдтэй, бакалавр, магистр, докторын түвшний 23.0 мянга орчим суралцагч, 750 гаруй эрдэмтэн багш, 1400 орчим үйлчилгээний ажилтантай Монгол улсын эрдэм оюуны томоохон төв юм.

1990-ээд оноос хойшхи шилжилтийн жилүүдэд МУИС өөрийн үйл ажиллагааг зах зээлийн зарчимд нийцүүлэн өөрчлөхөөс илүүтэйгээр оршин тогтнохын төлөө үйл ажиллагаа явуулж ирсэн. Энэ хугацаанд дээд боловсролыг шаталсан сургалтын тогтолцоонд шилжүүлэх, кредит системийг нэвтрүүлэх, их сургуулийг санхүүгийн хувьд өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчимд нийцүүлэн өөрчлөх, боловсролын агуулга, стандартыг өрнөдийн өндөр хөгжилтэй орнуудын их дээд сургуулиудын жишигт ойртуулахад чиглэсэн өөрчлөлтүүдийн эхлэлийг тавьсан боловч эдгээр өөрчлөлтүүд нь МУИС-ийг судалгааны их сургууль болгож өөрчлөх шаардлагад бүрэн нийцээгүй юм.

Ялангуяа сүүлийн нэг жилийн дотор МУИС дээр хэрэгжиж буй шинэчлэлийн бодлого нь өмнөх стратеги төлөвлөгөөг зайлшгүй эргэн харахад хүргэж байна. Энэ шинэчлэлийн гол агуулга нь:

- Их сургуулийн хөгжлийн гол хөдөлгүүр болсон багш, оюутны нөөц потенциалыг бүрэн дайчилж, сонголтоос өрсөлдөөн, өрсөлдөөнөөс чанарыг түрүүлдэг, эдийн засгийн хувьд үр ашигтай, нөөцийг оновчтой ашиглаж чадах, ахисан түвшний сургалт, салбар дундын судалгааг хөгжүүлэхэд тохиромжтой бүтэц зохион байгуулалтыг бий болгох, үүний дотор Хөтөлбөрийн хороо, мэдээллийн болон санхүүгийн нэгдсэн систем, сургалтын нэгдсэн алба, ерөнхий суурь хичээл гэх мэт салбар дундын сургалт, судалгааг дэмжих бүтцийг бий болгох,
- Орчин үеийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангаж чадах шилдэг мэргэжилтнийг бэлтгэхэд шаардлагатай хөтөлбөрүүдийг дэлхийн тэргүүлэх сургуулиудтай харьцуулсан жишгийн дагуу бий болгох,
- Шилдэг багш, шилдэг оюутнууд ажиллаж суралцах зайлшгүй нөхцлүүдийг хангасан сургалт судалгааны академик орчин нөхцлийг бүрдүүлсэн, хараат бус, биеэ даасан эдийн засаг, санхүүгийн бүтэц тогтолцоог бий болгоход чиглэж байгаа юм.

Ойрын жилүүдэд МУИС-ийн өмнө тулгараад буй хөгжлийн дараахь зорилтуудыг шийдвэрлэх шаардлагатай байна. Үүнд:

- МУИС судалгаа, сургалтын үйл ажиллагаа, хөтөлбөрөө тасралтгүй шинэчлэн сайжруулж чаддаг, шинжлэх ухаан технологийн хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцэж өөрчлөгддөг уян хатан тогтолцоог бий болгох, сонголт ба өрсөлдөөнийг дэмжсэн бүтцийн шинэчлэлийн дараагийн үе шатны зорилтуудыг хэрэгжүүлэх,

- Их сургууль дотоод зохион байгуулалтынхаа хүрээнд эрдмийн эрх чөлөөг баталгаажуулах, үйл ажиллагааныхаа бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн эрх зүйн шинэчлэлийг хийх,
- Оюутанд үзүүлэх үйлчилгээг чанарын шинэ түвшинд гаргах, судалгаанд суурилсан сургалтын суурь лабораторийг бэхжүүлэх, олон улсын түвшний салбар дундын нээлттэй, иж бүрдэл лабораторийг байгуулах, е-номын санг барих, зайн сургалтыг хөгжүүлэх, сургалт судалгааны орчин нөхцлийг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчилж, үр өгөөжтэй ашиглах,
- Ахисан түвшний сургалтыг эдийн засгийн үр ашигтай явуулж, суралцагчдыг шинэ мэдлэг бүтээх үйл ажиллагаанд идэвхтэй татан оролцуулах, гадаад харилцаа, олон талт хамтын ажиллагааны үр өгөөжийг бүрэн дүүрэн ашиглах;

МУИС-ийг 2011-2020 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн үеэс хойш стратеги төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах дор дурдсан зайлшгүй нөхцөл шаардлагууд бий боллоо. Үүнд:

- Улсын болон салбарын хөгжлийн бодлого, орчин нөхцөлд өөрчлөлт гарсан
- Стратеги төлөвлөгөөний хүрээнд дэвшүүлсэн зарим зорилтыг хэрэгжүүлсний зэрэгцээ тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага бий болсон
- Стратеги төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар тодорхой санал, санаачлагууд гарсан
- 2015 он хүртэл хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилтуудаа дүгнэх шаардлагатай болсон
- Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад хийсэн судалгааны ажлууд, удаа дараагийн хэлэлцүүлгүүдийн үр дүн, шинэ удирдлагын багийн үйл ажиллагааны шинэ хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг батлан гаргасан

II БҮЛЭГ. МУИС-ИЙН 2020 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ, ЕРӨНХИЙ ЗОРИЛГО

2.1 АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, УРИА, ҮНЭТ ЗҮЙЛС

АЛСЫН ХАРАА:

Дэлхийн стандартад нийцсэн, Монгол улсын хөгжил дэвшлийн тулгуур болсон үндэсний загвар судалгааны их сургууль байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Байгаль, нийгэм, хүмүүнлэгийн болон технологийн салбарт шинэ мэдлэг бүтээж, түгээн дэлгэрүүлдэг, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал бүхий үндэсний их сургууль байж, улс орны хөгжилд далайцтай хувь нэмэр оруулна.

УРИА:

“Жинхэнэ мэдлэг, хүнлэг ёс, оюуныг дээдлэнэ.”

“МУИС-ийн оюутан Монголын ирээдүй”

ҮНЭТ ЗҮЙЛС:

- Академик эрх чөлөө
- Сонголт ба өрсөлдөөн
- Сайн засаглал
- Нийгмийн хариуцлага
- Уламжлал ба шинэчлэл

2.2 2020 ОН ХҮРТЭЛХ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТУУД

- I. СУДАЛГАА, ИННОВАЦИ, АНТРЕПРЕНЁРШИПИЙН ОНОВЧТОЙ БҮТЭЦ, ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ
- II. НЭЭЛТТЭЙ, ӨРСӨЛДӨӨНД СУУРИЛСАН ЧАНАРТАЙ СУРГАЛТЫН ТОГТОЛЦООГ ТӨЛӨВШҮҮЛЭХ
- III. ОЮУТНЫ ХҮРТЭЭМЖТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ
- IV. СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ОРЧНЫГ ШИНЭЧЛЭХ
- V. УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ОНОВЧТОЙ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
- VI. ХӨГЖИЛД ЧИГЛЭСЭН НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ

I. СУДАЛГАА, ИННОВАЦИ, АНТРЕПРЕНЁРШИПИЙН ОНОВЧТОЙ БҮТЭЦ, ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ

МУИС-ийн өнөөгийн нөхцөл байдлаас үзэхэд, судалгаа шинжилгээ, инноваци, технологи дамжуулалт, антрепренёршипийн холбогдолтой журмуудыг баталж, бүтцийг бий болгосон хэдий ч судалгаа шинжилгээний үр дүнг практикт нэвтрүүлж, бизнестэй холбох тал дээр дорвитой ахиц гараагүй, оруулсан хөрөнгө оруулалт үр өгөөж муутай байна. МУИС-ийг сургалтад суурилсан их сургуулиас тогтвортой хөгжлийн үзэл баримтлал бүхий, академик мэдлэгийг нийгэм-эдийн засгийн эргэлтэд оруулдаг, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулдаг судалгааны их сургууль болгон өөрчлөхийн тулд судалгаа, шинжилгээний бодлогоо зах зээлийн суурь зарчимд нийцүүлэн өөрчилж, өрсөлдөөнд суурилсан, эдийн засгийн хувьд үр ашигтай тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байгаа юм. Суурь судалгааг хөгжүүлэхдээ төрийн дэмжлэгийг түлхүү авч, хэрэглээний судалгааг өөрийгөө санхүүжүүлэх зарчимд нийцүүлэн өөрчилж, судалгааны өрсөлдөөнт, уян хатан бус бүтцийг бий болгохыг зорьж байна. Өрсөлдөөний зарчимд тулгуурласан санхүүжилт, судалгааны хатуу тогтоосон бус, уян хатан бүтэц нь судалгаа шинжилгээний ажилд үр ашиг, үр дүн, хамтын ажиллагаа, чанарын ахиц дэвшлийг авч ирнэ хэмээн үзэж байна.

Их сургуулийн судалгааны үр дүнг нийгэм эдийн засгийн хөгжилд хэрэгцээтэй шинэ бүтээгдэхүүн бий болгохын тулд аж үйлдвэрт технологи дамжуулах, оюуны өмчийн хамгаалалт хийх, төр-их сургууль-аж үйлдвэрийн хамтын ажиллагааг дэмжсэнээр технологи дамжуулах буюу лицензийн төв (ТТӨ буюу TLO), оюуны өмчийн алба, стартап болон спин-офф компани, венч-капитал, судалгааны нээлттэй үндэсний төв, технологийн инкубатор, антрепренёршип боловсрол болон салбар дундын сургалт, судалгаа, инноваци, антрепренёршипийн санхүүгийн иж бүрэн тогтолцоог хөгжүүлэх, технологийн инновацийн дэд бүтцийг байгуулан үйл ажиллагааг тогтворжуулах шаардлагатай байдаг бөгөөд өнгөрсөн хугацаанд үүнтэй холбоотой зарим бодлого хөтөлбөрийг боловсруулж, холбогдох дүрэм журмыг боловсруулсан билээ.

Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх арга зам	Хэмжих үзүүлэлт
Судалгааны нээлттэй, өрсөлдөөнт, уян хатан тогтолцоог бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> • Өрсөлдөөнд тулгуурласан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх • Хатуу тогтоосон бус, уян хатан бүтцийг бий болгох 	<ul style="list-style-type: none"> ○ Томсон-Ройтерсийн индекстэй сэтгүүлүүдэд нийтлүүлэх өгүүллийн тоо
Олон улсын болон салбар дундын судалгаа, нийтлэлийг дэмжих, оюуны өмчийг хамгаалах	<ul style="list-style-type: none"> • Суурь судалгаанд авах улсын санхүүжилт, дэмжлэгийг нэмэгдүүлэх • Хэрэглээний судалгаанд өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмыг нэвтрүүлэх 	<ul style="list-style-type: none"> ○ Томсон-Ройтерсийн индекстэй сэтгүүлд Монголоос хэвлүүлсэн өгүүллийн тоо, эшлэл
Технологи дамжуулалт, инновац, антрепренёршипийн тогтолцоог дэмжих	<ul style="list-style-type: none"> • Судалгааны ажлын үр дүнг үнэлэх арга зүйг шинэчлэх (өгүүлэл, патент, орлого) • Олон улсын ба салбар дундын 	<ul style="list-style-type: none"> ○ Судалгаа шинжилгээний ажилд зарцуулах хөрөнгийн өсөлт ○ Судалгааны хүрээлэн, төв,

<p>Судалгааны нээлттэй орчин (open research facility), тэтгэлэгт хүрээлэн (Fellowship institute)-г байгуулан ажиллуулах</p>	<p>судалгааг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> • Шилдэг профессор, залуу судлаачдыг татах, ажиллах нөхцлийг бүрдүүлэх (head hunting) • Профессорт зохион байгуулалт, санхүү, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох • Судалгаанд зарцуулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, шилдэг судлаачдыг орон зайгаар хангах • Салбар дундын, нээлттэй, иж бүрдэл лабораториудыг шинээр байгуулах бодлого • Их сургууль хоорондын, их сургууль бизнесийн хамтын ажиллагааг хөгжүүлэх • Магистр, докторын оюутанд судалгааны туслах ажилтнаар ажиллах боломжийг нээж, холбогдох дүрэм журмуудад өөрчлөлт оруулах 	<p>лаборатори, эрдэм шинжилгээний ажилтны тоо</p> <ul style="list-style-type: none"> ○ Судалгааны ажилд хамрагдах магистр, докторын оюутны тоо, хувийн жин ○ Шинэ бүтээл, шинэ технологийг худалдаалснаас олох орлого ○ Патент, лицензийн тоо, орлого ○ Хоёрдмол харьяалалтай багш нарын хувийн жин
---	--	---

II. НЭЭЛТТЭЙ, ӨРСӨЛДӨӨНД СУУРИЛСАН ЧАНАРТАЙ СУРГАЛТЫН ТОГТОЛЦООГ ТӨЛӨВШҮҮЛЭХ

Сургалтын чанар хөтөлбөрийн агуулга, багшийн мэдлэг, ур чадвар, заах арга хэлбэр, элсэгчдийн чанар, оюутанд үзүүлэх дэмжлэг туслалцаа, үнэлгээ, суралцах боломж зэрэг олон хүчин зүйлсээс хамааралтай.

Бид шинэчлэн найруулсан стратеги төлөвлөгөөний хүрээнд сонголтоос өрсөлдөөн, өрсөлдөөнөөс чанарыг түрүүлдэг, эдийн засгийн хувьд үр ашигтай, нөөцийг оновчтой ашиглаж чадах, ахисан түвшний сургалт, салбар дундын судалгааг хөгжүүлэхэд тохиромжтой бүтэц зохион байгуулалтыг бий болгох замаар сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлж, дэлхийн тэргүүлэх сургуулиудтай харьцуулсан жишгийн дагуу хөтөлбөрүүдээ шинэчлэх замаар орчин үеийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангаж чадах шилдэг мэргэжилтнийг бэлтгэх боломжтой хэмээн үзэж байна.

Энэхүү стратеги төлөвлөгөөний хүрээнд кредит системийг сургалтад бүрэн нэвтрүүлж, их сургуулийн сургалт, судалгааны үйл ажиллагаа, хөтөлбөрийг тасралтгүй өөрчлөн

сайжруулдаг, нэг талаас оюутан багш нараас байнгын хүчин чармайлтыг шаарддаг, нөгөө талаас илүү их хөдөлмөрлөж буй багш, оюутанд илүү боломжийг бий болгодог өрсөлдөөнт тогтолцоог бүрдүүлж, эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтай бүтцийг бий болгох замаар их сургуулийн бүхий л түвшний сургалтыг өөрөө өөрийгөө хөгжүүлж чаддаг, бие даасан хөгжлийн замд оруулахад чиглэж байна. Энэ бүхний дүнд оюутан бүр өөрийн авьяас чадвар, хүсэл сонирхол, ирээдүйн хэрэгцээн шаардлагадаа үндэслэн мэргэжил, хичээл, багшаа сонгох, хос болон хавсарга мэргэжил эзэмших боломж бүрдэх болно.

Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх арга зам	Хэмжих үзүүлэлт
Хөтөлбөрийн шинэчлэлийг гүнзгийрүүлэх	<ul style="list-style-type: none"> ○ Хичээлийн агуулга, бүтцийг тасралтгүй сайжруулдаг системийг бий болгож, хөгжүүлэх <ul style="list-style-type: none"> • Мэргэжил, хичээл, багшаа сонгох чөлөөт сонголтыг нэмэгдүүлэх замаар өрсөлдөөнийг дэмжих • Хавсарга болон хос мэргэжлээр суралцах боломжийг нээх • Хөтөлбөрийн хороодын тогтвортой үйл ажиллагааг хангах • Хөтөлбөрүүдийг олон улсад магадлан итгэмжлүүлэх • Хөндлөнгийн үнэлгээг нэвтрүүлэх ○ Магистр, докторын хөтөлбөрийг хөгжүүлэх <ul style="list-style-type: none"> • Магистр, докторын сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэх • Магистр, докторын элсэлтийн бодлогыг шинэчлэх • Төгсөлтийн дараахь сургуулиудыг байгуулах • ТА, РА-ийг нэвтрүүлэх • Шилдэг оюутныг уялдуулсан хөтөлбөрөөр элсүүлэх ○ Сургалтын үйл ажиллагаан дахь техник, технологийн шинэчлэл <ul style="list-style-type: none"> • Цахим болон зайн сургалтын орчныг бий болгож хөгжүүлэх • Бие даан, идэвхтэй суралцах боломжийг бүрдүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Нэг хичээлийг зааж буй багшийн дундаж тоо, Сонголтод орсон багш, хичээлийн эзлэх хувийн жин • Хос ба хавсарга мэргэжил эзэмшиж буй оюутны хувийн жин • Төгсөх оюутны судалсан хичээлийн дундаж кредит • Төгсөөд 6 сарын дотор ажлын байраа олсон оюутны эзлэх хувь • Хөтөлбөрийн хороодын хуралдсан цаг • Олон улсад магадлан итгэмжлүүлсэн хөтөлбөрийн тоо • Элсэгчдийн дундаж оноо • Нийт оюутанд магистр, докторын оюутны эзлэх хувь • Нийт оюутанд гадаад оюутны эзлэх хувь • Цахим болон зайн
Сургалтын технологийн шинэчлэл		
Шилдэг, авьяаслаг оюутныг татах, элсүүлэх бодлого		
Сонголтоос өрсөлдөөн, өрсөлдөөнөөс чанарт шилжсэн нээлттэй сургалтыг бий болгож, кредит системийг бүх шатанд бүрэн нэвтрүүлэх		
Инженерийн боловсролыг дэмжих		

	<ul style="list-style-type: none"> • Элсэлтийг онлайн хэлбэрт бүрэн шилжүүлэх • Гадаад оюутныг элсүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох <p>○ Кредит системийг бүрэн нэвтрүүлж, салбар дунд, их сургуулиуд, улс хооронд нээлттэй, харилцан кредит солилцдог тогтолцоог бий болгох</p>	<p>сургалтад хамрагдаж буй оюутны тоо, хувийн жин</p> <ul style="list-style-type: none"> • Сургууль хооронд, их сургууль харилцан солилцсон кредитийн тоо
--	--	--

Ш. ОЮУТНЫ ХҮРТЭЭМЖТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ

Оюутны суралцах, амьдрах орчин нөхцлийг сайжруулж, тэдэнд хүртээмжтэй, тэгш шударга үйлчилгээг үзүүлэхийн тулд оюутанд хүргэх үйлчилгээний стандартыг боловсруулж, батлан мөрдөх шаардлагатай. Үүний зэрэгцээ магистр, докторын оюутныг судалгаа шинжилгээ хийх, багшлах ажилдаа татан оролцуулах, тэтгэлэг олгох, хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих зэргээр ажиллах, амьдрах, суралцах орчин нөхцлийг нь сайжруулахад чиглэсэн бусад арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх арга зам	Хэмжих үзүүлэлт
Оюутанд хүргэх үйлчилгээний стандартыг боловсруулж мөрдөх	<ul style="list-style-type: none"> • Оюутанд үзүүлэх бүх төрлийн үйлчилгээний зураглалыг хийж, тэдгээр үйлчилгээний стандарт, холбогдох журам, заавруудыг батлан гаргах 	<ul style="list-style-type: none"> • Оюутны сэтгэл ханамжийн үнэлгээ • Үйлчилгээний нэг ажилтанд ногдох оюутны тоо
Оюутны тэтгэлэг, ассистантшип тогтолцоог хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> • Журам, заавруудыг хэрэгжүүлэх дэд бүтцийн орчин нөхцөл, програм хангамжийг бүрдүүлэх • Оюутны үйлчилгээний ажилтнуудыг сургах, бэлтгэх 	<ul style="list-style-type: none"> • Оюутны үйлчилгээнд зарцуулсан төсвийн хэмжээ • Оюутанд олгох тэтгэлэгийн өсөлт
Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	<ul style="list-style-type: none"> • Оюутны үйлчилгээг үнэлэх үнэлгээний нэгдсэн системийг бий болгох • Ассистантшипээр ажиллуулах боломжийг үүсгэх • Оюутныг хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээг хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Ассистантаар ажиллах магистр, докторын оюутны тоо • Хөдөлмөр эрхэлдэг оюутны хувийн жин

IV. СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ОРЧНЫГ ШИНЭЧЛЭХ

Орчин үеийн их сургуулийн сургалт, судалгааны хэрэгцээ шаардлагыг хангасан, багш судлаачид болон оюутнууд бие даан хөгжих боломжийг бүрдүүлсэн, тэдэнд суралцах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, тав тухтай ажиллаж амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх нь дэлхийд өрсөлдөх чадвартай оюутан бэлтгэх, дэлхийн түвшний судалгааг хийхэд онцгой чухал ач холбогдолтой.

Ирэх жилүүдэд их сургуулийн сургалт судалгааны орчин нөхцөлд гарсан өөрчлөлтөд нийцүүлэн шинжлэх ухаан технологийн сүүлийн үеийн ололт амжилтад тулгуурласан мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх, салбар дундын судалгааны нээлттэй лабораториудыг байгуулах, электрон номын санг байгуулах зорилтуудыг дэвшүүлж байгаагийн зэрэгцээ судалгааны төслүүдийг санхүүжүүлэх хөрөнгө босгох төслийг дэмжих нэгжийг байгуулж, хөгжлийн санг сонгодог утгаар нь хөгжүүлж, хөрөнгө оруулалтын нэгдмэл бодлого төлөвлөлтийг бий болгож, их сургуулийн алс хэтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн их сургуулийг хотхоноор хөгжүүлэх болно.

Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх арга зам	Хэмжих үзүүлэлт
Үүлэн технологид суурилсан мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх	<p>Сургалт, судалгаа, удирдлага, төлөвлөлт, хүний нөөц, санхүү бүртгэлийн дурдсан үйл ажиллагааг хамарсан нэгдсэн системийг хөгжүүлнэ. Энэ хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • мэдээллийн нэгдсэн системийн программ хангамжийг хөгжүүлэх, • техник технологийн шийдлийг боловсруулж, бий болгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> • Мэдээллийн нэгдсэн бааз бий болсон байна • Мэдээллийн нэгдсэн системийн техник технологи, программ хангамжийн орчин нөхцөл бүрдсэн байна • Үүлэн технологид суурилсан бүрэн компьютержсэн удирдлагын үйл ажиллагаа нэвтэрсэн байна.
Сургалт, судалгааг дэмжих бүтцийг хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> • Дэлхийн түвшний, салбар дундын судалгааны, нээлттэй, иж бүрдэл (mixed) лабораториудыг байгуулах • e - номын сан бий болгож, номын фондыг чанаржуулах • Төслийг дэмжих нэгж (Grant support office)-ийг байгуулах 	<ul style="list-style-type: none"> • Салбар дундын шинжтэй, судалгааны нэгдсэн иж бүрдэл лабораториудтай болсон байна • Удирдлагын нэгдсэн систем, шинжлэх ухаан технологийн олон улсын сүлжээнд холбогдсон e-номын сантай болсон байна. • Төслийг санхүүжүүлэх чиглэлд босгосон хөрөнгийн хэмжээ

Хөрөнгө оруулалтын бодлогын шинэчлэл	<ul style="list-style-type: none"> Хөрөнгө оруулалтын нэгдмэл бодлого, төлөвлөлт Хөгжлийн санг сонгодог утгаар нь хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> Хөрөнгө оруулалтын зардлыг төсвийн орлогын 15-20%-д хүргэнэ. Хөгжлийн санд цуглуулах хандив, тусламжийн орлогын өсөлт Хөрөнгө оруулалтын өсөлт
Их сургуулийн хотхоныг хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> Хотхоныг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулах Хотхоныг хөгжүүлэхэд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх 	<ul style="list-style-type: none"> Их сургуулийн хотхоноор хөгжүүлэх төлөвлөгөөтэй болно. Хотхоноор хөгжүүлэх чиглэлд эхний хөрөнгө оруулалтуудыг хийнэ.

V. УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ОНОВЧТОЙ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Их сургуулийн удирдлагын үйл ажиллагаа нь ил тод нээлттэй байх, хариуцлагатай байх, оролцоонд тулгуурлах зарчмуудад тулгуурлан явагдах бөгөөд нэг талаас, удирдлагын үйл ажиллагаанд орчин үеийн техник технологийн дэвшил, түүний дотор үүлэн технологид тулгуурласан мэдээллийн нэгдсэн тогтолцоог ашиглах, нөгөө талаас ажлын гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн дэвшилтэт аргууд, түүний дотор гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг ашиглах замаар үйл ажиллагааны дээрх зарчмуудыг хангах болно.

Удирдлагын үйл ажиллагааг боловсронгуй болгохын зэрэгцээ шилдэг багш, судлаачид ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэх, хүний нөөцийн удирдлага төлөвлөлтийг боловсронгуй болгох талаар дэс дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх арга зам	Хэмжих үзүүлэлт
Дотоод үйл ажиллагааны нэгдмэл стандартыг бий болгож, нэвтрүүлэх	<ul style="list-style-type: none"> Их сургуулийн дотоод үйл ажиллагааны дүрэм журмуудыг боловсронгуй болгож мөрдүүлэх, удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох замаар тэдгээрийг хувь хүнээс үл хамаарах, стандартчилагдсан үйлчилгээ болгон хөгжүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> Дотоод үйл ажиллагааны нэгдсэн дүрэм журам Удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг үйл ажиллагаандаа	<ul style="list-style-type: none"> Үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжих системчилсэн арга болох гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг ашиглах 	<ul style="list-style-type: none"> Бүрэлдэхүүн сургууль, тэнхим, хөтөлбөр, багш нарын ажлын гүйцэтгэлийг

нэвтрүүлэх	замаар сонголт ба өрсөлдөөнд тулгуурласан ажлын гүйцэтгэлийг хэмжиж хянана	
Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бүтээлтэй шилдэг судлаач, багш нарыг татах, ажиллах нөхцлийг бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> • Багш судлаачдын хөдөлмөрлөх орчин нөхцлийг сайжруулах • Хоёрдмол харьяалал • Багшийг дэмжих хөтөлбөр 	<ul style="list-style-type: none"> • Дундаж цалингийн өсөлт • Хоёрдмол харьяалалтай багш нарын тоо • Багшийг дэмжихэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ
Хүний нөөцийн удирдлага, төлөвлөлтийг боловсронгуй болгох	<ul style="list-style-type: none"> • Ил тод нээлттэй байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлж, оролцоог нэмэгдүүлэх • Удирдлагын мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх • Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ • Сонголт ба өрсөлдөөнийг дэмжсэн хүний нөөцийн бодлогыг хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Багш, ажилтнуудын тогтвор суурьшил • Багш нарын сэтгэл ханамжийг дээшлүүлэх

VI. МУИС-ИЙН НИЙГМИЙН ХӨГЖИЛД ОРУУЛАХ ХУВЬ НЭМРИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ

Орчин үед их сургуулийн нийгэмд үйлчлэх үүрэг, нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх нь дэлхий нийтийн глобал асуудал болжээ. Аливаа их сургуулийн хамт олон юуны өмнө өөрсдийн сайн сайхан байдал, эд баялгийн хүртээмжийн төлөө ажиллах бус олон нийт, нийгэмд үйлчлэх зорилгоо тэргүүн зэрэгт тавих хэрэгтэй болоод байна. Улсаас өгөх санхүүжилтийн дэмжлэг, их сургуулийн бие даасан байдал академик эрх чөлөөг өргөжүүлэхийн хэрээр түүний нийгэмд үйлчлэх үүрэг, нийгмийн хариуцлагын шаардлага нэмэгддэг зүй тогтолтой байна. Тиймээс 2020 он хүртэлх стратегийн нэг гол тэргүүлэх чиглэлд их сургуулийн нийгэмд үйлчлэх асуудлыг онцгойлон оруулж байна. Энэ хүрээнд их сургуулийн нийгмийн хариуцлагын үзэл баримтлалаа нарийвчлан боловсруулах, нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг бүх хэлбэрээр хөгжүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийгмийн хариуцлагын стандартыг хэрэгжүүлж эхлэх, уг чиглэлд сургууль, тэнхим, хувь хүмүүсийн оруулж байгаа хувь нэмэр, үр дүнг хэмжиж, үнэлж, урамшуулж чадах тогтолцоог бүрдүүлэх ажил, үе шаттайгаар хэрэгжих болно.

Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх арга зам	Хэмжих үзүүлэлт
Шинэ мэдлэг бий болгох, шинжлэх ухааны мэдлэг, ололтыг нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчилах, соён гэгээрүүлэх, олон нийт, нийгэмд чиглэсэн үйлчилгээгээ нэмэгдүүлэх замаар их сургуулийн нэр хүнд, нийгмийн хариуцлагыг дээшлүүлнэ	<ul style="list-style-type: none"> • Нийгэмд чиглэсэн арга хэмжээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн сайн сайхны төлөө хийсэн ажлын тоо
Багш, оюутнууд нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаанд оролцох нөхцөл боломжийг бүрдүүлж, зарцуулсан хүч хөдөлмөрийг үнэлэх тогтолцоог нэвтрүүлнэ.	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн сайн сайхны төлөө зарцуулсан хүч хөдөлмөрийг зохих ёсоор үнэлэх, үүний тулд холбогдох дүрэм журмуудыг боловсруулна 	<ul style="list-style-type: none"> • Сургалтад хамрагдсан, мэргэжил дээшлүүлсэн хүний тоо • Хамтын ажиллагааны гэрээ хэлцлийн тоо
Захиалгат судалгааг гүйцэтгэх, сургалт явуулах зэргээр олон нийт, төр, хувийн хэвшилтэй нягт хамтран ажиллаж, хамтын ажиллагаанаас олох орлогыг нэмэгдүүлнэ.	<ul style="list-style-type: none"> • Хамтын ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх Бүтцийг байгуулна • Сургалтын модулиудыг бий болгох 	<ul style="list-style-type: none"> • Хамтын ажиллагааны гэрээ хэлцлийн тоо • Хамтын ажиллагаанаас олох орлого

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТУУД	СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА					
	2015	2016	2017	2018	2019	2020
Стратегийн тэргүүлэх чиглэл 1. Судалгаа, инноваци, антрепренёршикийн оновчтой бүтэц тогтолцоог хөгжүүлэх						
Судалгааны нээлттэй, өрсөлдөөнт, уян хатан тогтолцоог бүрдүүлэх						
Олон улсын болон салбар дундын судалгаа, нийтлэлийг дэмжих, оюуны өмчийг хамгаалах						
Технологи дамжуулалт, инновац, антрепренёршикийн тогтолцоог дэмжих						
Судалгааны нээлттэй орчин (open research facility), тэтгэлэгт хүрээлэн (fellowship institute)-г байгуулах						
Стратегийн тэргүүлэх чиглэл 2. Нээлттэй, сонголт, өрсөлдөөнд суурилсан чанартай сургалтын тогтолцоог төлөвшүүлэх						
Хөтөлбөрийн шинэчлэлийг гүнзгийрүүлэх						
Сургалтын технологийн шинэчлэл						
Шилдэг, авьяаслаг оюутныг татах, элсүүлэх бодлого						
Сонголтөөс өрсөлдөөн, өрсөлдөөнөөс чанарт шилжсэн нээлттэй сургалтыг бий болгож, кредит системийг бүх шатанд бүрэн нэвтрүүлэх						
Инженерийн боловсролыг дэмжих						
Стратегийн тэргүүлэх чиглэл 3. Оюутны хүртээмжтэй үйлчилгээг хөгжүүлэх						
Оюутанд хүргэх үйлчилгээний стандартыг боловсруулж мөрдөх						
Оюутны тэтгэлэг, ассистантшип тогтолцоог хөгжүүлэх						
Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих						
Стратегийн тэргүүлэх чиглэл 4. Сургалт, судалгааны орчныг шинэчлэх						
Үүлэн технологид суурилсан мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх						
Судалгаа, сургалтыг дэмжих бүтцийг хөгжүүлэх						

Хөрөнгө оруулалтын бодлогын шинэчлэл						
Их сургуулийн хотхоныг хөгжүүлэх						
Стратегийн тэргүүлэх чиглэл 5. Удирдлага, хүний нөөцийн оновчтой бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх						
Дотоод үйл ажиллагааны нэгдмэл стандартыг бий болгож, нэвтрүүлэх						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх						
Шилдэг судлаач, багш нарыг татах, ажиллах нөхцлийг бүрдүүлэх						
Хүний нөөцийн удирдлага, төлөвлөлтийг боловсронгуй болгох						
Стратегийн тэргүүлэх чиглэл 6. Хөгжилд чиглэсэн нийгмийн үйлчилгээг хөгжүүлэх						
Шинэ мэдлэг бий болгох, шинжлэх ухааны мэдлэг, ололтыг нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчилах, соён гэгээрүүлэх, олон нийт, нийгэмд чиглэсэн үйлчилгээгээ нэмэгдүүлэх замаар их сургуулийн нэр хүнд, нийгмийн хариуцлагыг дээшлүүлнэ						
Багш, оюутнууд нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаанд оролцох нөхцөл боломжийг бүрдүүлж, зарцуулсан хүч хөдөлмөрийг үнэлэх тогтолцоог нэвтрүүлнэ.						
Захиалгат судалгааг гүйцэтгэх, сургалт явуулах зэргээр олон нийт, төр, хувийн хэвшилтэй нягт хамтран ажиллаж, хамтын ажиллагаанаас олох орлогыг нэмэгдүүлнэ.						